

ЯПОН УЛС

Б. Сэржав

Япон улс Ази тивийн зүүн хэсэгт хойноосоо урагшаа нийт 3000 км үргэлжлэн орших арлын орон юм. Японы арлуудад Хоншюү, Шикокү, Күшюү, Хоккайдогийн дөрвөн арлаас гадна том жижиг 4000 гаруй арал багтдаг. Нутаг дэвсгэрийн нийт хэмжээ 378 мянган хавтгай дөрвөлжин км ажээ.

Номхон далай, Япон тэнгисээр хүрээлүүлсэн тус орон далайн чийглэг, зөөлөн, дулаан уур амьсгалтай. Газар нутгийнхаа байрладаас шалтгаалан уур амьсгалын ялгаа ихтэй. Номхон далай захиалсан хэсэгтээ зун нь чийглэг бүгчим халуун, өвөл нь цэлмэг, хуурай уур амьсгалтай байхад Япон тэнгис захиалсан хэсэгтээ өвөл нь их хур тундастай, баруун хойт талын Нийгатагийн хавьд зарим жилд 4–5 м цас унадаг нь дэлхийд 4 цөөхөн тохиолдол гэнэ. Хойт талын Хоккайдогоос бусад нутагт 6–р сарын сүүлчээс 7–р сарын дунд үе хүртэл борооны улирал үргэлжилнэ. 8–р сараас 10–р сард Японы баруун, баруун өмнөд хэсэгт далайн хэр салхины аюул тохиолдох нь олонтаа.

Нийслэл Токнод жилийн дундаж температур 15 хэм, хамгийн дулаан нь зундаа 33–34 хэм, хамгийн хүйтэн нь өвөлдөө –5–аас –4 хэм хүрдэг. Токнод жилд унах хур тундасны хэмжээ 1,503 мм.

Япон арлууд ерөнхийдөө уулархаг. Нутгийн 70%-ийг эзлэх уул

Б. Сэржав-ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан

нуруудын ихэнх нь өй модоор бүрхмэл. Нийт нутгийн 15%-ийг газар тариаланд ашиглаж, 3%-ийг орон сууц, дөнгөж С, 4%-ийг үйлдвэр, албан байгууллагын талбай эзэлдэг ажээ. Хүн амын оршин суух боломжтой нутгийн 1 х. д. км талбайн хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны нягтрал ихтэй. Япончууд 1 х. д. км талбайд оногдох хүн амаар Баруун Герман, Англиас 4 дахин, Америкаас 30 дахин илүү ажээ.

Хоншюү арлын төв хэсгээр Хида, Кисо, Акабшигийн нурууд үргэлжлэн тогтсон бөгөөд тэдгээр уулсын зарим нь далайн төвшнөөс 3000 м өндөр ажээ. Дэлхийд зартай, үзэсгэлэнт Фүжи уул далайн төвшнөөс 3, 776 м өргөгджээ.

Эндхийн голууд ерөнхийдөө богинохон, уулын түргэн урсгалтай, хамгийн урт гол Шинно 367 км. Уулсын хөндийд тунгалаг нуур элбэгтэй. Хамгийн том Бива нуур 674 х. д. км талбайтай, хамгийн гүн Тазава нуурын усны гүн 423 метр ажээ.

Япон улс 123 сая 500 мянган хүн амтай. Эрүүл ахуйн нөхцөл, эмчилгээ, сувилгааны хөгжил, хоол хүнсний тэжээллэг чанар сайжирснаас сүүлийн жилүүдэд нас баралт эрс буурлаа. Одоо японы эрэгтэйчүүд дунджаар 75, 9, эмэгтэйчүүд нь 81, 8 нас насалж урт наслалтаараа дэлхийд эхний байранд орлод байна. Хүн амын бүтэц урьд өмнө байгаагүй насжих хандлагатай болж, урт наслалт цаашидч үргэлжилнэ гэж эрдэмтэд тооцоолж байна. Өндөр настнууд /65-аас дээш настан/ 1975 онд японы хүн амын 7, 9%-ийг, 1985 онд 10, 3%-ийг эзэлж байсан бол 2000 онд 16, 3% болох тооцоо гарчээ. Хүн амын 70% гаруй нь зам тээвэр, аж үйлдвэр хөгжсөн, зөөлөн дулаан уур амьсгалтай далай захалсан районд шигүү суурьшдаг. Аж үйлдвэрийнхээ хөгжлийг дагаж хүмүүс хотод олноор /нийт хүний 80%/ суурьшиж, газар тариаланд ажиллагсад цөөрсөөр байна.

Токио хот захын дүүргийнхээ хамт 12 сая хүн амтай байгаа нь Шанхай хотын дараа дэлхийд хоёрдугаарт орно.

Үндэсний гарал үүслийн тухайд япон хүүхдүүд эхээс төрөхдөө голдуу монгол тамга хэмээх хөх мөнгөтэй төрдгөөр нь монгол угсаатанд хамааруулан үзэх нь олонтаа.

Японы арлуудад хуучин чулуун зэвсгийн үеэс хүн суурьшиж эхэлсэн гэж үздэг. Тухайн үед хамаарах эд өлгийн зүйлс, чулуун зэвсгийн үеийн элдэв олдвор элбэг олджээ.

Төр улс үүсч бий болсон тухайд манай тооллын анхдугаар зууны үед японд 100 гаруй жижиг улс тархай бутархай оршин тогтнож байсан боловч яваандаа нэгдэж нэгэн улсыг бий болгожээ.

ҮШ зууны үед зохиосон түүх Кожики /Эртний үйл явдлын тэмдэглэл/ болон японы түүхийн бусад сурвалж бичгүүдэд МЭӨ 660 онд анхны эзэн хаан Жинмү улсыг байгуулж, хаан ширээнд суусан гэж тэмдэглэжээ. Жинмү хаан ширээнд заларсан өдөр нь одоогийн тооллоор хоёрдугаар сарын II-ний өдөр учраас энэ өдрийг улс байгуулсан өдөр болгож үндэсний баяраар тогтоожээ.

Арлын улсын хувьд гаднын түрэмгийллээс ангид байж, бас эх газраас тийм ч алслагдаагүйн ачаар гаднын дэвшилт соёлыг нэвтрүүлэхийн зэрэгцээ өөрийн өвөрмөц соёл иргэншлийг бүтээсээр орчин үед дэлхийн тэргүүний орны зэрэгт нэгэнт хүрлээ.

Япончуудын өвөг дээдэс эртнээс загас, ан эгнуурын олзоор аж төрсөөр ирсэн бөгөөд Яён үе буюу III зуунаас японч нутагт тутарга тарвалж, аж ахуйд төмөр эдлэлийг хэрэглэх болсон зэргээр япон маягийн аж ахуйн хэвцэл тогтож, түүнээс хойш тутаргын тариаланг голлох болжээ.

Дундад зууны үе буюу XII зуунд самурай нар хүчирхэгжин засгийн эрхийг авч, тариачдыг эрхшээлдээ оруулжээ. Энэ засаглал XIX зууны сүүлч хүртэл 700 гаруй жилийн турш оршин тогтносон байна.

XVII зууны эхэн үеэс гадаад ертөнцтэй харилцах харилцааг тасалж хаалгтай орон болжээ. Эдийн засагт газар тариалан голлож байсан ч ээжмаар аж үйлдвэр, худалдаа хөгжиж XVIII-XIX зуунд харьцангуй

энх тайван цаг байснаас худалдаачдын эрх мэдэл дээшилж иржээ. Мөн соёл, боловсрол хөгжиж орчин үеийн улсын суурь дэвсгэр бий болжээ.

1853 онд Америкийн адмирал Перигийн хөлөг онгоц Японд ирснээр хаалтай улсын үе төгсгөл болж, гадаад ертөнцтэй худалдаа харилцаа сэргэжээ. Энэ шинэ нөхцөл феодалын засаглал урьдын хэвээр оршин тогтноход саад учруулж 1868 онд Эзэн хаанаар толгойлуулсан шинэ засгийн газар байгуулж эх орноо европын тэргүүний орнуудтай эн сацуу хөгжүүлж орчин үеийн улс болгох бодлогыг тууштай баримталсан нь Мэйжигийн шинэчлэлт гэж алдаршжээ. Мэйжигийн үе эхэлснээс хойш 20 гаруй жилийн дотор засгийн газрыг байгуулах шинэ системийг нэвтрүүлж, шинэ үндсэн хуулиар парламентын зохион байгуулалт, шүүх прокурорын бие даасан байдал, ард түмний эрх үүргийг тогтоожээ. Энэ шинэтгэлээр хуурай замын цэргийг германы загвараар, далайн цэрэг, орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалтыг английн загвараар сольжээ. Эдийн засгийн хувьд газрын шинэчлэл хийж, улсын үйлдвэрүүдчйг дэмжих бодлого баримталж, мөнгөний системийг өөрчилжээ. Нийгэм соёлын хувьд сургуулийн системийг шинээр бий болгож, феодалуудын аж ахуй, нийгмийн онцгой эрхийг хүчингүй болгож, америк, европын соёлыг чөлөөтэй нэвтрүүлжээ.

Улс орны дотоодод XIX зууны сүүлчээс аж үйлдвэрийн хувьсгал эхэлж капитализм хөгжиж, дэлхийн I дайны дараагаас улс төрийн олон намын систем хэрэгжиж эхэлжээ. Гэвч 1929 оны дэлхийн их хямралын нөлөөгөөр милитаризм сэргэж, японы гадаад улс төрийн байдлыг хурцатгаж, 1937 онд Зүүн хойт хятадад дайн үүсгэжээ. 1941 оны 12 дугаар сар гэхэд Америк, Англи улсуудтай Номхон далайд дайн эхэлсэн байлаа.

1945 онд Япон улс дайнд бууж өгсний дараа холбоотон гүрнүүдийн оролцоотойгоор улс төр, нийгэм эдийн засаг, соёл боловсролын бүх салбарт шинэчлэл хийж, хуучин армийг тараан, энх тайвнаар хөгжих замд дахин оржээ.

Мэйжи-ийн засгийн газар улс орноо дэлхий дахинд нээлттэй болгож, улсаа баяжуулан эдийн засгийг хөгжүүлж цэргийн хүч чадлыг зузаатган, улс орны тусгаар тогтнолыг тууштай дэмжиж байжээ. Мэйжи-ийн засгийн газар байгуулагдсанаас дэлхийн II дайн хүртэл 80-аад жилийн хугацаанд эдийн засгийн өсөлт жилд дунджаар 4-5% байсан нь тухайн үеийн Америк, Европын хүчирхэг орнуудын хөгжлөөс ч өндөр байлаа.

Энэ хөгжлийн шалтгааныг олон зүйлээр тайлсаар ирсэн боловч улс орныг жолоодогчид идэвхтэй нээлттэй бодлогын далбаан дортэргүүний технологи, системийг нэвтрүүлж, үүндээ хамгийн зөв хэлбэрээр зоригтойгоор хөрөнгө зоорио зарцуулж, хүн хүч дайчилжээ. Ард түмэндээ ялангуяа залуу үед тэрхүү тэргүүний технологи, системийг япон маягаар хүлээн авч, цааш хөгжүүлж чадахуйц болсвсрол мэдлэгийг эзэмшүүлжээ. Тариачид, үйлдвэрийн ажилчид, худалдаачдыг анги ялгаварлан үзэхийг болиулж, ард түмэндээ бүх нийтийн боловсролын тэгш системийг тогтоосон. Японыг орчин үеийн улс болгоход нийт ард түмний мэдлэгийн төвшинг өндөр байлгах шаардлагтай гэдэг үзлийн үүднээс суралцагсдын тос өсгөж, боловсон хүчин бэлтгэхэд анхаарч 1872 онд Франц, Америкийн боловсролын системд үндэслэсэн сургуулийн шинэ системийг бий болгожээ.

Орчин үеийн Япон улс цагаан өнгийн үндсэн дэвсгэр дээр улаан нарыг дүрсэлсэн төрийн далбаатай. Энэ далбаа XVI зууны үеэс Японыг төлөөлөх болж, наран мандах орон гэсэн утгатай улсын нэрэндээ ч дүйсэн учир 1870 онд албан ёсоор төрийн далбаа болгожээ. Мэйжи-гийн Эзэн хаан 1872 онд Японы анхны төмөр зам нээх ёслолд энэ төрийн далбааг анх удаа өргөн мандуулжээ.

Япон улс 16 дэлбээт удвал цэцгийг төрийн сүлдийн утгаар хэрэглэдэг. Япон улсын төрийн дуулал нь одоогоос 1000-аад жилийн өмнө зохиосон Кимигаёо гэдэг дуу юм. Үгийг зохиогч нь тодорхойгүй, аяыг нь Мэйжи-ийн үед Хаяаши Хиромори гэдэг хүн зохиожээ.

Японд улсын цэцэг, улсын шувуу гэж бий. Япон улсын цэцэг нь энкура, шувуу нь гургууль юм. Ер нь Японы аймаг, муж, хот тосгон бүр тус тусын цэцэг, шувуутай.

Японд эртнээс эриний тооллыг хэрэглэж иржээ. XIX зууны сүүлч Мэйжи-ийн үеэс Эзэн хаан бүр хаанчлалынхаа үед тус тусын эриний тооллыг хэрэглэх болжээ.

Одоогийн Эзэн хаан 1989 онд ширээнд сууж эриний нэрээ Хэйсэй гэж нэрлэжээ. Энэ 1992 он бол Хэйсэйн 4 он юм. Эдүгээ албан ёсны бичиг баримтал эриний тооллыг хэрэглэж байгаа ч олон нийтийн дунд европын тооллыг өргөн хэрэглэдэг.

Одоо мөрдөж буй 1947 оны 5-р сарын 3-нд баталсан Үндсэн хуульд зааснаар Эзэн хаан нь "Бүрэн эрхт ард түмнийхээ хүсэл бодлыг нилэрхнийлэн төр улс, хүн ардынхаа эв нэгдлийн бэлэг тэмдэг" болж байдаг. Эзэн хаан улс төрийн үйл ажиллагаа явуулахгүй харин ёслолын чанартай төрийн үйл ажиллагаа явуулж байхаар үндсэн хуулиар заасан бөгөөд энэ ажиллагаа нь засгийн газрын зөвлөлгөө, зөвшөөрөлтэй явагдах ажээ. Үүнд: парламентаас нэр дэвшүүлснээр засгийн газрын ерөнхий сайдыг томилж, үндсэн хуулинд өөрчлөлт оруулах, хууль дүрэм гэрээ хэлэлцээрийг батлах, парламентийг зарлан хуралдуулах-, парламентийг тарааж, сонгуулийг зарлан явуулах, галдар цол, одон медаль шагнаж, гадаад харилцааны бичиг баримт батлах, гадаадын элчин төлөөлөгчдийг хүлээн авах зэрэг орно.

Япон улсын одоогийн 125 дахь эзэн хаан Акихито 1933 оны 12-р сарын 23-нд төрж, 1989 онд хаан ширээнд заларчээ. Японд Эзэн хаанаа сэрүүн тунгалаг байхад нэрийг нь дууддаггүй, нас эцэслэсний дараа түүний хаан суусан эриний нэрээр дууддаг заншилтай. Тухайлбал 124 дэх эзэн хаан Хирохито нэртэй байсан боловч хаан суусан эриний нэр Шёва учир таалал төгссөнөөс хойш Шёвагийн эзэн хаан гэж дуудаж байна.

Хатан хаан Мичико 1934 онд төрж 1959 онд хаан хүүтэй гэрлэжээ. Эзэн хааных 2 хүү, 1 охинтой, хаан хүү Нэрухито 1960 онд төрсөн. Японы Гакушюүин их сургууль, Английн Оксфордын их сургуулийг төгсчээ.

Япон улсын засаглалын бүтэц нь хууль тогтоох, засаг захиргаа, шүүхийн байгууллага тус бүр бие даан орших санхүү бүрнцү /Эрх барих 3 байгууллагын бие даан орших/ системтэй.

Хууль тогтоох парламент нь төрийн эрх барих хамгийн дээд байгууллага бөгөөд хууль тогтоох цорин ганц байгууллага юм. Зөвлөхүүдийн болон төлөөлөгчдийн 2 танхимаас бүрдэж төлөөлөгчид нь бүх ард түмнээс сонгогдоно.

Парламент нь засгийн газрын ерөнхий сайдыг томилж, засгийн газрын бүрэлдэхүүнийг хэлэлцэж батлах, хуулийн төслийг хэлэлцэх, улсын төсвийг хэлэлцэж батлах, гэрээ хэлэлцээрийг зөвшөөрөх, шүүхийн байгууллагад санал оруулах, үндсэн хуулинд засвар оруулах санал гаргах зэрэг үйл ажиллагаа явуулна.

Засаг захиргааны эрхийг барих засгийн газар нь Ерөнхий сайд болон бусад сайд нэрээс бүрдэж засаг захиргааны үйл ажиллагааны асуудлаар парламентийн тэмцэж харууллага хүлээнэ. Засгийн газар нь засаг захиргааны ерөнхий асуудлаас гадна хууль тогтоомжийг хэрэгжүүлж, гадаад харилцааг зохион байгуулж, гэрээ хэлэлцээрийг байгуулж, төсвийг боловсруулж, засгийн газрын тогтоол шийдвэрийг гэрлэнэ. Эдгээр ажил үүргийн гүйцэтгэх 12 яамны тус тусын сайдээр тэргүүлүүлэн байгуулна. Ерөнхий сайд нь яамдын сайдыг томилж, халах эрхтэй.

Япон улс нь орон нутгийн захиргааны 47 нэгжид хуваагдана. Түүнд нийслэл Токіо хот, тусад нь засаг захиргааны нэгж болгон аач үедээ Хоккайдо арлын дээдсээр багтана. Мужууд болон гэдгээрийн хот, тосгон тус тусдаа орон нутгийн хуралтай, түүний гишүүд нь сонгуулиар шууд сонгогдоно.

Япон улсын шүүхийн байгууламж нь улсын дээд шүүх, бусад шүүхээс бүрдэнэ. Улсын дээд шүүхийн даргыг засгийн газрын нэр дэвшүүлснээр

Эзэн хаан томилж, бусад шүүхийн даргыг засгийн газраас томилно.

Парламентын гишүүд, нийслэл, муж, аймаг, хот, тосгодын дарга, тэдгээрийн хурлын гишүүдийг сонгуулиар шууд сонгоно.

20 насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй бүх иргэн сонгох эрхтэй.

Зөвлөхүүдийн танхимын гишүүн, нийслэл, муж, аймгийн даргад 30-аас дээш насны иргэд, хот тосгодын даргад 25-аас дээш насны иргэд сонгогдох эрхтэй. 1945 онд эмэгтэйчүүдэд сонгох, сонгогдох эрхийг олгожээ.

Парламентын гишүүд, нийслэл, муж, аймгийн дарга нар тэдгээрийн хурлын гишүүдийн ихэнх нь аль нэг намын гишүүн, эсвэл аль нэг намаас нэр дэвшсэн хүмүүс юм. Харин хот тосгодын дарга нар тэдгээрийн хурлын гишүүдийн дунд намын харьяалалгүй хүмүүс нэлээд байдаг ажээ.

Эдүгээ Японд Либерал ардчилсан нам, Японы социалист нам, Комэн нам, Ардчилсан социалист нам, Японы коммунист нам, Социал демократ холбоо зэрэг улс төрийн намууд ажиллаж байна.

Сонгуулийн өмнөх кампанийг зураг, реклам, телевиз, олон нийтийн хуралд илтгэл хийх, маргаан арилцлага явуулах, гудамж талбайд илтгэл хийх зэргээр өргөн хүрээтэй явуулна. Гагцхүү үймээн будлиан үүсгэж болохуйц хэт олон удаагийн урна сурталчилгаа мөн хээл хахуультай холбогдож болох айл гэрээр хийх сурталчилгааг хориглодог.

Япон улс 1956 онд НҮБ-д гишүүнээр элсчээ. Өнгөрсөн хугацаанд Япон улс НҮБ-ын зорилго зарчмын дагуу олон улсын энх тайван аюулгүй байдалд хувь нэмэр оруулах, өөрийн улсын аюулгүй байдал хөгжил цэцэглэлийг хангах, Ази, Номхон далайн бүс нутгийн улсын хувьд тус бүс нутгийн энх тайван, хөгжил цэцэглэлд хувь нэмэр оруулах энх тайванч бодлогыг баримталж ирлээ.

Япон улс эдгйн засгаа сүүлийн 40-өөд жилд маш түргэн хөгжүүлж, эдийн засгийн асар их хүч чадлыг эзэмшин, дэлхийн тэргүүний аж үйлдвэржсэн орны нэг боллоо.

Дэлхийн II дайнаас хойш эдийн засгийн дундаж өсөлт дайны дараах сэргэлтийн жилүүдэд /дайн дууссанаас 50-иад оны эхний хагас хүртэл/ 8, 5%, жигд өндөр хөгжлийн жилүүдэд /50-иад оны сүүлийн хагасаас 60-аад он/ 1% байсан бөгөөд 70-аад оноос хойш энэ хурдац бага зэрэг буурсан хэдий ч олон улсын хэмжээнд авч үзвэл өндөр байлаа. Япон улс урьд өмнө хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн голлон үйлдвэрлэж байсан бол энэ хугацаанд тэргүүний технологийн үндсэн дээр голдуу химийн болон хүнд үйлдвэрийн сайн чанарын бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний төрөл бүрийн эд бараа үйлдвэрлэдэг боллоо. Ийм хөгжлийнүр дунд 1988 он гэхэд нийгмийн нийт бүтээгдэхүүн 2, 850 триллион ам. долл, түүний хүн ам тутамд ногдох хэмжээ 23, 3 мянган ам. долгарт хүрч, энэ үзүүлэлтээр АНУ, Шведийг гүйцэж түрүүлэн дэлхийд эхний байрт, мөн онд худалдааны нийт хэмжээ 437, 1 млрд долл. болж АНУ-ын дараа II байрт оржээ. Импортоос давсан экспортын хэмжээ 79 млрд долларт хүрсэн нь дэлхийд урьд өмнө байгаагүй үзүүлэлт болжээ. Гадаад худалдааны ашгийн хуримтлал 1987 онд 240, 7 млрд долларт хүрч, энэ үзүүлэлтээр Англи улсаас давж дэлхийд тэргүүн байрт оржээ. Зөвхөн 1990 онд Япон улсын гадаад худалдаанд экспорт 286 млрд, 945 сая ам. долл, импорт 234 млрд, 796 сая ам. долл болжээ.

Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн хувьд бүр 70-аад онд ган, хөлөг онгоц, автомашин үйлдвэрлэлээр тоо, чанарын аль аль үзүүлэлтээр дэлхийд тэргүүн байранд гарч, сүүлийн жилүүдэд тэргүүний өндөр технологи голлосон аж үйлдвэрийн робот, хагас дамжуулагч, электрон техникийн бараагаар мөн тэргүүн байрт нэгэнт орлоо. Мэдээлэл, үйлчилгээний салбар ч дэлхийн тэргүүний түвшинд нэгэнт хүрчээ. Эдийн засгийн цар хэмжээ материаллаг үйлдвэрлэлийн тухайд Мэйжи-ийн шинэчлэлийн үеэс зорьж ирсэн "хөөж гүйцэх, гүйцэж түрүүлэх" мөрөвдөл нэгэнт биеллээ.

1990 оны үзүүлэлтээр Япон улсын нийгмийн нийт бүтээгдэхүүн 3, 316

триллион ам. долл / 435 триллион иен / бөгөөд түүний жилийн дундаж өсөлт 1985–1989 онд 4,5% байсан бол 1990–91 онд 5,7% болж өссөн байна. Хойшид нийгэм насжих сөрөг хандлага буй хэдий ч электроник төхөөрөмж голлосон шинэ өндөр технологийн тусламжтайгаар нийгмийн нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг 3–5%-д тогтмол байлгах боломжтой гэж үзэж байна. 2000 он гэхэд энэ үзүүлэлт жилдээ 4% байна гэж японы эрдэмтэд тооцоолжээ.

1990 оны байлалаар хүн ам тутамд ногдох үндэсний орлого 23365 ам. доллар байна.

Японд нийт 61 сая 230 мянган хүн ажил эрхэлж байгаагийн 7,6% нь үйлдвэрлэлийн I салбар буюу хөдөө аж ахуйд, 31,6% нь үйлдвэрлэлийн II салбар буюу уул уурхай, аж үйлдвэр, барилгад, үлдсэн 60,8% орчим нь үйлдвэрлэлийн III салбар буюу худалдаа, үйлчилгээ, зам тээвэр, холбоо, эрчим хүч, дулаан, нийтийн хоолны салбарт ажиллаж байна. Эдийн засгийн цар хэмжээ тэлж, хөгжил түргэсэхийн хирээр ажиллагсад орлого ихтэй салбарт шилжин ажиллах үзэгдэл түгээмэл болж үйлдвэрлэлийн I салбарт ажиллагсдын тоо эрс буурч III салбарт ажиллагсдын тоо эрс өсөх хандлагатай болоод байгааг дээрх тоон үзүүлэлтээс төвөггүй харж болно.

Үйлдвэрлэлийн I салбарын хувьд улс ардын аж ахуйд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эзлэх хувь сүүлийн жилүүдэд буурах хандлагатай боллоо. Дотоодын нийт үйлдвэрлэлд эзлэх газар тариалангийн хэмжээ гэхэд 1970 онд 6,1% байсан бол 1986 онд 2,9% болж, загас агнуур, ой, газар тариалангийн үйлдвэрлэл нийтдээ буурчээ. Хөдөө аж ахуйд түүний дотор газар тариаланд 4 сая 360 мянга, загасны аж ахуйд 140 мянган хүн ажиллаж байгаа бөгөөд энэ нь нийт ажиллагсдын 8%-д ч хүрэхгүй байгааг дээр дурьдсан билээ. Тариачин өрхийн тоо эрс хорогдож 1960 онд байсан 6 сая 60 мянган өрх 1987 он гэхэд 4 сая 270 мянган өрх болж хорогджээ. Ялангуяа газар тариалан дагнан эрхэлж байсан 2 сая 80 мянган өрх 630 мянган өрх болж удам залгах тариачингүй өрх олчирч байна. Энэ нь хөдөө аж ахуйн салбарт бүтцийн өөрчлөлт гарч, эдийн засаг олон улсын шинжтэй болж, хүнсний бүтээгдэхүүний импорт ихэсч байгаатай холбоотой ажээ.

Эрэлт хэрэгцээний өсөлт болон дотоод гадаад үнийн зөрүү зэрэгтэй холбогдон Япон улс дэлхийд хүнсний зүйлийг хамгийн ихээр импортлодог орон боллоо. Хүнсний зүйлийн импорт үнийн дүнгээр 1975 онд II млрд. 200 сая доллар байсан бол 1987 онд 21 млрд 100 сая доллар болж 2 дахин өсчээ. Хүнсний бүтээгдэхүүнийг Америкаас хамгийн ихээр оруулж /1987 онд 7 млрд. 300 сая доллар, хүнсний зүйлийн нийт импортын 35% / мөн Австрали, Хятад, Канадаас голдуу худалдан авч байна. Ялангуяа үр тариа, эрдэнэ шиш, буудайн импортлоор дэлхийд тэргүүлж байгаа бөгөөд хэрэгцээт цагаан будаагаа 100%, хүнсний ногоог 95%, сүү, сүүн бүтээгдэхүүнийг 86% дотоодын бүтээгдэхүүнээр хангаж байна. Сүүлийн жилүүдэд хүнсний ногоо, жимс жимсгэнэ, мах махан бүтээгдэхүүн /шувуу, гахай / өндөгний үйлдвэрлэл дээшилж ирлээ.

Үйлдвэрлэлийн II салбарын онцлогоос дурьдвал аж үйлдвэрт сүүлийн жилүүдэд бүтцийн ихээхэн өөрчлөлт гарлаа. Үүнд дайнаас хойш түүхий эд, эрчим хүчийг асар ихээр зарцуулж, нүсэр том орон зай, тээврийн хэрэгсэл шаардах овор ихт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж иржээ. Үйлдвэрийн газрууд ч өөрөө нүсэр байлаа. Энэ шинжээр нь аж үйлдвэрийг "жюү-кэ-чю-дай" /хүнд-зузаан-урт-том / гэсэн үгээр төлөөлүүлэн нэршиж иржээ. Хэдийгээр хүнд аж үйлдвэр эдийн засагт чухал байр суурь эзэлсэн хэвээр байгаа боловч нэмүү өртөг ихтэй, өндөр технологийн, оюуны хөдөлмөр голлосон хөнгөн авсаархан бүтээгдэхүүн тухайлбал компьютер, хагас дамжуулагч, албан тасалгааны техник хэрэгслүүд, видео кассет зэргийг үйлдвэрлэх аж үйлдвэрүүд зэрэгцэн хөгжиж байна. Ийм үйлдвэрүүд нь түүхий эд, эрчим хүчийг зарцуулалт бага, өмнөх хүндхийн үйлдвэрийн адилаар асар том үйлдвэр-

рийн газар, тоног төхөөрөмж шаардахгүй, үйлдвэрлэлийн үр ашиг сайтай, бүтээгдэхүүн нь эрэлт хэрэгцээ ихтэй зэргийг харгалзан өмнөх "жюү-ко-чио-дай" шинжийн эсрэгээр "кей-хаку-тан-шо" / "хөнгөн-нимгэн-богино-бага" гэж үйлдвэрлэлийн шинжийг тодорхойлох боллоо. Ер нь уламжлалт хөдөө аж ахуй, боловсруулах аж үйлдвэр, барилгын салбарт ч гэсэн автоматжуулалт, механикжуулалт нэвтэрч, өндөр технологи голлон оюуны хөдөлмөр төвлөрсөн шинжтэй болж үйлдвэрлэлийн салбарууд холимог шинжтэй болж, тухайлбал хөдөө аж ахуйн салбар гэхэд хөдөө аж ахуй-аж үйлдвэр хосолсон, аж үйлдвэрийн салбар гэхэд аж үйлдвэр-худалдаа, -үйлчилгээ хосолсон шинж улам гүнзгнйрч байна. Данрамд эдийн засгийн хөгжлийн чухал хөшүүрэг болох технологийн шинэчлэлийг хийхэд зориулсан шинэчлгээ судалгааны ажлын зардлын талаар товч дурдъя. Япон улс 1987 онд энэ зардалд нийгмийн нийт бүтээгдэхүүнийхээ 2, 52% буюу 8 триллион 414, 9 млрд иен зарцуулсан нь 10 жилийн өмнөхөөс 2 дахин их байжээ. Эрдэм шинжилгээний ажлын зардлын 90 гаруй хувийг аж үйлдвэрийн судалгаа шинжилгээнд зарцуулж байгаа бөгөөд тухайлан холбоо, электроникийн салбар, автомашин, химийн аж үйлдвэрийн судалгааны зардал бусдаар өндөр байна.

Орчин үед эдийн засгийн хөгжилтэй уялдан технологийн экспорт, импорт өргөжиж Хойд Америкийн технологийг голдуу импортгоор авч /импортоор авч буй технологийн 57%/, экспортолж буй технологийн 40 орчим хувийг Азийн орнуудад гаргаж байна.

Японы аж үйлдвэрт 1990 онд 13 сая 486 мянга 700 гаруй автомашин, 99 сая тн ган үйлдвэрлэжээ. Мөн 2 сая 900 мянга гаруй персональ компьютер, 5 сая 800 мянга гаруй хувиллагч машин, вордин процессор, 15 сая 80 мянга гаруй ширхэг хагас дамжуулагч үйлдвэрлэжээ.

Японд нийт 1 сая 851 мянга 670 гаруй фирм, компани, корпораци ажиллаж байна. Мөн 719 мянга 900 гаруй аж үйлдвэрийн газар байна. Эдгээрийн дотор эхний 100 үйлдвэр нь нийт хөрөнгийн 4-ийг 1-ийг эзэмшиж байгаа бөгөөд үйлдвэрлэлийн бүх салбарт 100 сая иен хүртэлх үндсэн хөрөнгөтэй, 300-аас доош ажиллагсадтай жижиг дунд үйлдвэр голлох суурийг эзэлж байна. Эдгээр жижиг дунд үйлдвэр нь нийт үйлдвэрийн дотор 99, 3%-ийг эзэлж, нийт ажиллагсдын 81% нь энд ажиллаж байна. Ялангуяа үйлчилгээний салбар, жижиглэн худалдаалах салбарт жижиг дунд үйлдвэр зонхилж, аж үйлдвэрийн салбарт савхин эдлэл, нэхмэл сүлжмэл, хүнс, металл боловсруулах үйлдвэрийн 80, 6% нь 50 хүртэл ажилчинтай жижиг үйлдвэрүүд юм. Жижиг дунд үйлдвэр, том үйлдвэрийн хооронд үйлдвэрлэлийн чанарын болон орлого цалингийн зэрэг үндсэн ялгаанууд оршоор ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд технологийн шинэчлэлт хийж үйлдвэрлэлийн бүтцийг боловсронгуй болгосон зэргээр дээрх ялгааг багасгах, ялангуяа жижиг дунд үйлдвэрт ажиллагсдын цалинг том үйлдвэрт ажиллагсдын цалингийн түвшинд ойртуулах хандлага их болж байна. Одоо ажиллагсдын сарын дундаж цалин 350 мянган эн буюу 2, 8 мянган ам. долл байна.

Одоо Японн үйлдвэрийн газруудын 50, 3% нь 7 хоногт таван ажлын өдөртэй болжээ. 1990 оны байдлаар хөдөлмөр эрхэлж буй нэг хүн жилдээ 2168 цаг ажиллаж байгаа нь Баруун Герман, Францынхаас 500 цаг, Америк, Английнхаас 200 цагаар илүү байна.

Аж ахуйг явсан маягаар эрхлэх хэд хэдэн арга байдаг. Үүнд:

а/ Японы пүүсүүд бөртөө ажиллах хүнийг насан туршид нь баталгаатай хөдөлөн алдаг,

б/ Ажилласан жил, насыг нь харгалзан дэс дараалсан журмаар дүгнүүлэн, амьгаа урамшил, албан тушаал олгодог,

в/ Ажлын бүтээл, пүүсийн орлогыг харгалзан жилд тогтмол хугацаанд цалингийн шагнал олгодог арга зэрэг юм. Эдгээр нь хөдөлмөрчин хүн тогтвор суурьшилтай ажиллах, пүүсдээ өөрийнхөө хандгах, зохилсон ажилдаа амжилт гаргах янз бүрийн талын хөшүүрэг болж өгдөг байна. Тухайлбал, жилд хоёр удаа цалингийн шагнал

олгодог бөгөөд хэмжээ нь тухайн хүний хийсэн хөдөлмөр, үйлдвэр, пүүсийн ашиг орлого, улсын эдийн засгийн тухайн үеийн байдал зэргээс хамаарах авч дунджаар нэг хөдөлмөрчин жилийн цалин дээрээ шагналын 5, 5 сарын цалинг нэмж авдаг нь нэгэнт хэвшил болоод байна.

Японы ардын боловсролын системийн дагуу бүх хүүхэд бага сургуульд 6 жил, бүрэн бус дунд сургуульд 3 жил суралцдаг бөгөөд 9-р анги төгсгөл үнэ төлбөргүй сурдаг. Одоо сургуулийн насны бүх хүүхдийн 99, 9% нь бага, бүрэн бус дунд сургуульд суралцаж байна. Хичээлийн жил 4-р сард эхэлж, дараа жилийн 3-р сард дуусдаг. Суралцагчид бүх нийтийн 9 жилийн сургалтын дараа 3 жилийн хугацаатай бүрэн дунд сургууль, 5 жилийн хугацаатай техник мэргэжлийн сургуульд элсдэг. Бүрэн дунд сургууль төгсөгчид их төлөв 4 жилийн хугацаатай төрөл бүрийн дээд сургуульд, нэг хэсэг нь 2 жилийн сургалттай коллежид элсдэг. Японд 500 орчим их, дээд сургууль, 540 гаруй хоёр жилийн коллеж бий. Цэцэрлэгээс их сургууль хүртэлх бүх шатны сургуулиудад 1986 оны байдлаар 27 сая 540 мянган хүн суралцаж байсан нь нийт хүн амын 22, 7%-ийг эзэлж байжээ. Нэг хүүхдэд дээд сургууль төгсөх хүртэлх боловсролын зардал дунджаар 24 сая эн зарцуулж байна.

1984 оны байдлаар нийтийн номын сан 1642, урлагийн музей 193, түүхий музей 90, шинжлэх ухааны музей 77, амьтны хүрээлэн 36, ургамлын цэцэрлэг 27 байлаа.

Японы эдийн засгийн хүч чадал, хэмжээ далайц өргөжихийн хэрээр хөгжиж байгаа орнуудтай хамтран ажиллах замаар тэдгээр улсуудад үлэмж их тусламжийг үзүүлсээр ирлээ. Япон улс 1954 оноос засгийн газрын түвшинд эдийн засгийн тусламж үзүүлж эхэлсэн бөгөөд энэ нь мөнгөн зээлэг, буцалтгүй тусламж, техникийн хамтын ажиллагаа, төлбөрийн зэрэг олон хэлбэрээр хэрэгжиж байна. 1978 оноос хойш Засгийн газрын тусламжийн 3 удаагийн зорилтыг дэвшүүлж хэрэгжүүлээд байна. 1986-1992 онд хэрэгжүүлэх 7 жилийн хугацаатай 3 дахь удаагийн тусламжийн программаар хөгжиж байгаа орнуудад нийт 40 млрд гаруй долларын тусламжийг үзүүлэх, зөвхөн 1992 онд 1985 оны 3 млрд 800 мян долларас 2 дахин их тусламж үзүүлэхээр төлөвлөсөн байна. Хөгжиж байгаа орнуудад үзүүлж буй засгийн газрын тусламжийн /ODA/ хэмжээ Японы нийгмийн нийт бүтээгдэхүүний 0, 3%-тай тэнцэж байгаа бөгөөд тусламжийн хэмжээ сүүлийн жилүүдэд өмнөх жилийнхээс 10 гаруй хувь нэмэгдэж иржээ. Энэ хугацаанд Япон улс хамгийн их тусламж үзүүлж байсан улс 1976 онд Бирма, Филиппин зэрэг 6 орон байсан бол 1980 онд 15, 1986 онд 25 болж өслөө.

Энэ удаагийн засгийн газрын тусламжийг бүс нутгаар авч үзвэл Азийн орнуудад тусламжийн 65%-ийг, үлдэх 35%-ийг Африк, Дундад Дорнод, Төв болон өмнөд Америк гэсэн 3 бүс нутагт тэнцүү хэмжээгээр үзүүлэхээр төлөвлөжээ. Тусламжийг бие хүн төлөөлөх, газар тариалан, эрчим хүч, нийгмийн дэд бүтцийг сайжруулах салбарыг үндэслэн үзэхийн зэрэгцээ боловсрол, эрүүл мэнд, хүн амын зэрэг тухайн бүс нутгийн оршин суугчдын аж амьдралыг дээшлүүлэхэд шууд үүрэг гүйцэтгэж чадахуйг объектыг сонгон туслах чиглэл баримталаар ажээ. Японы засгийн газраас явуулж буй техникийн хамтын ажиллагаа нь 1954 оноос эхлэн хэрэгжсэн бөгөөд гол нь хөгжиж байгаа орнуудын эдийн засаг нийгмийн хөгжилд чухал шаардлагатай техник технологийг нэвтрүүлэх, техник технологийн төвшинг дээшлүүлэх зорилготой ажээ. Энэ тусламжийг хэрэгжүүлэх зорилгоор 1974 онд Япония олон улсын хамтын ажиллагааны агентлаг (JICA) -ийг байгуулсан юм. Техникийн хэрэгсэл ажиллагааны шугамаар жил бүр хэдэн мянган мэргэжилтнийг хүлээн авч мэргэжлийг нь дээшлүүлж байгаагийн зэрэгцээ засгийн газрын байгууллагууд, туршилт эрдэм шинжилгээний газрууд, үйлдвэрүүд, сургууль, чадралаа сургуультай газруудад олон төрлийн мэргэжилтнүүдийг илгээн ажиллуулж байна. Мөн багаж төхөөрөмжийн туслалцаа, янз бүрийн төслүүдийн санхүүжилт, харилцаа оруулалт, технологи сургалтын төвүүдэд үзүүлэх тусламж эрүүл мэнд эмчилгээ, хүн амын г.з бүл

төлөөлөлтийн хамтын ажиллагаа, газар тариалан, өйн салбарт үзүүлэх тусламж зэрэг олон хэлбэрийн хамтын ажиллагаа явуулж байна.

Одоогоос 20 жилийн өмнө 1972 оны 2-р сарын 24-нд Монгол улс Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосон билээ. Энэ хугацаанд хоёр орны харилцаа улс төр, худалдаа эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн зэрэг олон салбараар өргөжин хөгжиж ирлээ. Япон улсын Гадаад явдлын Яамны сайд 1989 онд Монголд, Монгол улсын засгийн газрын тэргүүн 1990 онд Япон улсад, Япон улсын засгийн газрын Ерөнхий сайд 1991 онд Монголд айлчилсан нь хоёр орны харилцаа хамтын ажиллагааг улам урагш гхиулах шинэ сайхан боломжийг нээлээ. 1972 онд худалдааны нийт эргэлт 1,1 сая. ам. долл байсан бол 1991 онд 21,1 сая. ам. долларт хүрч даруй 19,2 дахин нэмэгдэв. Энэ хугацаанд Монгол улс хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн төрөл бүрийн ноос, ноолуур, адууны дэл сүүл, сүлжмэл эдлэл, зэсийн баяжмал зэргийг Япон улсад экспортолж, японы ертөн хэрэгцээний бараа, үйлдвэрийн болон техникийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, цахилгаан хөдөлгүүр, эмнэлгийн багаж төхөөрөмж зэргийг худалдан авч байлаа.

Манай улсын эдийн засгийн хөгжлийг түргэсгэхэд тус дэмжлэг үзүүлэх зорилгоор ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоногдсон Говь комбинатыг Япон засгийн газрын буцаалтгүй олгосон хөрөнгөөр байгуулж ашиглалтанд оруулсан нь Япон улсаас үзүүлж ирсэн тусламжийн анхны том үр дүн байлаа. Түүнээс хойш 1991 оныг хүртэл эрүүл мэндийн салбарт оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж суурилуулах, Боловсролын салбарт сургалтын зориулалттай персональ компьютер, сургалтын бусад техник хэрэгсэл, их сургуулийн иж бүрэн лингафонный кабинет гэх зэрэг нийт 5 млрд 600 сая гаруй иений буцаалтгүй тусламжийг олгосон юм. Түүнээс гадна дээрх хугацаанд техникийн хамтын ажиллагааны шугамаар аж үйлдвэр, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, соёлын салбарын төрөл бүрийн мэргэжлийн 100 орчим хүнийг хүлээн авч мэргэжлийг нь дээшлүүлэхийн зэрэгцээ өөрийн мэргэжилтнийг илгээн ажиллуулж байна.

1991 оны 8-р сард Японы ерөнхий сайд манай оронд айлчлах үеэр Монгол улсад тулгарч буй эдийн засгийн бэрхшээлийг даван туулахад зориулж Японы засгийн газраас 50 сая орчим ам. долларын буцаалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийг олгох, нийт 940 гаруй сая иений сансрын холбооны Интелсат системийн станц байгуулах төсөл хэрэгжүүлэх улс ардын аж ахуйн төрөл бүрийн салбарын хэрэгцээнд зориулж 35 сая долларын хөнгөлөлттэй зээл олгохоор болсон билээ. Түүнээс гадна гааль, худалдааны хөнгөлөлт гэх зэрэг янз бүрийн тусламж дэмжлэгийг үзүүлдэг байна.

Ийнхүү Монгол улсад асар их тусламжийг Япон улс өөрөө үзүүлж ирсэн бөгөөд үүгээр ч зогсохгүй олон улсын хэмжээнд Монгол улсад дэмжин туслах үйл ажиллагааг идэвхтэй санаачлан дэлхийн банк, Олон улсын валютын сантай хамтран Монголыг дэмжигч орнуудын хуралдааныг удаа дараа зохион байгуулсан нь өнөөгийн хүнд бэрхшээлийг даван туулахад манай улсад чухал дэмжлэг тусламж болох нь мэдээж билээ.

Гэлцхүү манай улсын хувьд Япон улсаас үзүүлж буй асар их тусламжийг үр ашигтай зарцуулан, эдийн засгийн бүтцийг дорентой өөрчлөн өнөөгийн хямралт байллыг хурдан хугацаанд даван туулах, экспортын нөөцөө нэмэгдүүлэн цаашид бие даан хөгжих үндсийг зөв оновчтой тавих чухам л Япон улс гаднын тусламж нөлөөг япон маягаар шингээж Япон маягаар хөгжиж чадсан шиг энэ их тусламжийг монгол маягаар хүлээн авч монгол орноо хөгжүүлэхэд зөв ашиглахсан.

1. Нихон /Япон улс/, Токио, 1989

2. Нихон кэйзай зүсэцу. /Японы эдийн засгийн тухай график, тайлбар/, Токио, 1989

3. Хэйсэй 3 нэн. Кэйзай хакүшэ. /Хэйсэй 3 он. Эдийн засгийн цагаан ном/, Токио 1991

4. Хэйсэй 3 нэн. Кокумин сэйгацү хакушэ. / Хэйсэй 3 он. Ард түмний эж амьдралын цагаан ном/, Токио, 1991
5. Нихон кэйзай / Японы эдийн засаг/ шинэ үн, 1992 оны дугаарууд.
6. Кэйзай шихно-но кэндокоро. / Эдийн засгийн үзүүлдэлтүүдний гол тойм/, Тоёяма кэн, 1990 он
7. "Зүүн хойт Ази судлал" сэтгүүл, 1992 № 1
8. Гэндай ёого-но кисочингүки, / Орчин цагийн нэр томъёоны үндсэн мэдлэг/, 1992
9. Хэйсэй 3 нэн. Чюү шёо кигио хакушэ / Хэйсэй 3 он. жижиг дунд үйлдвэрийн цагаан ном/ Токио, 1991.